



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 102

Дадал сум

Ахмад настанд хүндэтгэл үзүүлж  
золгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5, Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц сангийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сарын баярыг тохиолдуулан сумын 80-аас дээш ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааны зардал гаргасугай.

2. Ахмадуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Үйл ажиллагааны зардлын 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ш.МОНХХУЯГ

0120000060